



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 14

Мөрөн

**“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн Төлөөлөн
Удирдах зөвлөлийн цалин тогтоох,
2017 оны зардал батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 56 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалингийн зардлыг 01 дүгээр хавсралтаар баталсугай.

2. “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлыг 31,437,200 /гучин нэгэн сая дөрвөн зуун гучин долоон мянга хоёр зуу/ төгрөгөөр тогтоож, 02 дугаар хавсралтаар баталсугай.

3. Батлагдсан цалинг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

4. Компанийн удирдлагын зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороонд даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР


010039

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн
14 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралт

“ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ийн ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ

№	Албан тушаал	Үндсэн цалин /төгрөг/
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	260,000
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд	200,000
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	350,000

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн
14 дүгээр тогтоолын 02 дугаар хавсралт



"ХӨВСГӨЛ УС СУВАГ" ХХК-ИЙН ТУЗ-ИЙН 2017 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын төсөв	Нийт зардал
1	Цалингийн зардал	26,520,000
2	НДШ	2,917,200
4	Шуудан холбоо	200,000
5	Бичиг хэргийн зардал	700,000
6	Хурлын зардал	900,000
7	Шатахуун	200,000
	ДҮН	31,437,200